

ӨМНӨХ ҮГ

МУИС-ийн оюуны өмчийг эдийн засгийн эргэлтэд оруулах, инновацийн судалгаа шинжилгээний ажил, төсөл хөтөлбөрүүдийг зах зээлийн эрэлт, хэрэгцээтэй уялдуулах, их сургууль-аж үйлдвэрийн хамтын ажиллагаанд багш оюутны хамтын оролцоог идэвхижүүлэх, багш судлаачдын хамтарсан гарааны компани байгуулахад дэмжлэг үзүүлэх зорилгоор 2018 оны 5 дугаар сараас 11 дүгээр сар хүртэл хугацаанд “Багш, оюутны стартап-2018” (NUM STARTUP 2.0) хөтөлбөрийг хэрэгжүүлсэн билээ.

Тус хөтөлбөрийн хүрээнд Хэрэглээний шинжлэх ухаан, инженерчлэлийн сургууль (ХШУИС)-ийн Ургамлын биотехнологийн лабораторийн ахлах багш, доктор Б.Даваапүрэв, Шинэ материалын лабораторийн доктор Б.Цэрэнханд, Сэргээгдэхэрчим хүчний лабораторийн дэд проф. А.Амарбаяр, Хүрээлэн буй орчин, химийн инженерчлэлийн тэнхмийн дэд проф. Т.Энхдөл, Шинжлэх ухааны сургууль (ШУС)-ын БУС-ын Эмчилгээний хүнс ба байгалийн нэгдлийн химийн лабораторийн дэд проф. Б. Мөнхжаргал, доктор Б. Туяагэрэл, Байгалийн нэгдлийн химийн лабораторийн дэд проф. Ш. Наранмандах, Бизнесийн сургууль (БС)-ийн Менежментийн тэнхмийн багш магистр Д. Батцэцэг, Олон улсын харилцаа, нийтийн удирдлагын сургууль (ОУХНУС)-ийн дэд проф. С. Энхцэцэг нараар ахлуулсан магистр, бакалаврын оюутнууд хамтран гарааны компани байгуулах төслийн баг бүрдүүлж оролцлоо.

Та бүхэнд энэхүү танилцуулгаар дамжуулан МУИС-ийн дэргэд албан ёсоор байгуулагдсан “Гарааны Эм Би Пи Лаб” ХХК, “Дижитал Солюшнс” ХХК компаниуд болон тус хөтөлбөрийн хүрээнд гарааны компани байгуулахаар бойжиж буй төслүүдийг танилцуулж байгаадаа баяртай байна.

Цаашид манай эрдэмтэн багш, судлаачид, оюутнууд болон үйлдвэрлэл, бизнес эрхлэгчдийн бүтээлч хамтын ажиллагаа өргөжиж, Монгол улсын хөгжилд бодит үр дүн өгөх өргөн боломж бий гэдэгт итгэж байна.

МУИС-ийн Инноваци, технологи дамжуулах төв



“ГАРААНЫ ЭМ БИ ПИ ЛАБ” ХХК

ҮҮСГЭН БАЙГУУЛАГЧ:

Профессор Ж.Батхүү

ХШУИС, Хими, биологийн инженерчлэлийн тэнхим

БАТГА ЭМЧЛЭХ PHYTO-ACNE БЭЛДМЭЛ

МУИС-ийн Биоорганик хими-Фармакогнозын лабораторит хийгдэж буй in vitro скрининг судалгааны явцад Залесовын эдгэлж ургамал нь бактерийн эсрэг өндөр идэвхтэй нь 2008 онд тогтоогдсон юм. Увс, Говь-Алтай, Баянхонгор аймгийн нутагт уулын ам, гуу, жалга, хөндийд ургадаг уг ургамлын ид цэцэглэлтийн үед хүн, мал дотор нь орж хөдөлгөх үед ургамлын гадарга дээр цагаан өнгөр үүсгэн тогтсон бодис нь манарч, хүн найтаалгаж, мал тургиж тавгүйтна. Үүнийг нь нутгийн ардууд мэддэг болохоор тухайн ургамал элбэг ургасан газрыг Найтуурын хөндий гэж нэрлэдэг билээ.

Ургамлын хоруу чанарын судалгааг Монос Эм судлалын хүрээлэн, бактерийн эсрэг идэвхт нэгдлийн судалгааг Хими, химийн технологийн хүрээлэн, Япон улсын Тохокүгийн анагаах ухаан, эм зүйн их сургуультай, Монгол хүний батга үүсгэгч, эмгэгшүүлэгчийн зүйлийн бүрдэл тодорхойлох судалгааг Арьсны өвчин судлалын үндэсний төв, Япон улсын Тохо их сургуультай хамтран гүйцэтгэсэн юм. Залесовын эдгэлж нь хоруу чанар багатай, түүнд агуулагдаж буй фенолт липид нэгдлүүд нь бактерийн эсрэг өндөр идэвхтэй болох нь тогтоогдсон. Залесовын эдгэлж ургамлын ханд агуулсан энэхүү Phyto-acne бэлдмэл нь ижил төрлийн импортын бүтээгдэхүүнтэй харьцуулахад Монгол хүний батга үүсгэгч, эмгэгшүүлэгчийн эсрэг идэвхи сайтай, Монгол хүний арьсны онцлогт тохирсон бүтээгдэхүүн юм.

Энэ бүтээгдэхүүн нь Монгол, Японы эрдэмтдийн 10 жилийн судалгааны ажлын үр дүн, Монгол улсын 4182 тоот патент, лицензийн гэрээ, барааны тэмдэгт, үйлдвэрлэгчийн стандарт БСО1:2017, МХЕГ-ын Хүнсний аюулгүй байдлын үндэсний лавлагаа лабораториудын дүгнэлтээр баталгаажсан болно.

Энэ бүтээгдэхүүн нь Монгол, Японы эрдэмтдийн 10 жилийн судалгааны ажлын үр дүн, Монгол улсын 4182 тоот патент, лицензийн гэрээ, барааны тэмдэгт, үйлдвэрлэгчийн стандарт БС01:2017, МХЕГ-ын Хүнсний аюулгүй байдлын үндэсний лавлагаа лабораториудын дүгнэлтээр баталгаажсан болно.



☎ 99633663, 89945037, 99298515

🌐 covidit_tsatsa@gmail.com, oyunbileg0515@gmail.com,
jbatkhuv@num.edu.mnv



“ДИЖИТАЛ СОЛЮШНС” ХХК



ҮҮСГЭН БАЙГУУЛАГЧ:

Профессор А. Энхбаяр

МУИС, ХШИУС, Хэрэглээний математикийн тэнхим

Компьютер график, мультимедиа судалгааны нээлттэй лаборатори нь 2015 онд Дээд боловсролын шинэчлэлийн төслийн хүрээнд Азийн хөгжлийн банкны санхүүжилттэйгээр байгуулагдсан. Тус лабораторид хэрэглээний математик, компьютерийн ухаан, програм хангамж, электроникийн чиглэлийн 20 орчим багш, судлаач, бакалавр, магистр, докторын түвшний оюутнууд судалгаа хийдэг.

Манай зорилго нь компьютер график, виртуал реалити, аугментэд реалити, симуляци зэрэг шинжлэх ухаан, технологийн тэргүүлэх чиглэлээр дэлхийн түвшний харилцан уялдаатай, нэгдмэл судалгааг хийж, эдгээр салбарт мэргэжилтэн бэлтгэх, шинэ мэдлэг болон технологи бий болгох, гарааны компаниуд байгуулж өөрсдийн инноваци шингэсэн бүтээгдэхүүнүүдийг эдийн засгийн эргэлтэнд оруулах явдал юм.

Тус компани нь манай лабораторийн боловсруулсан шинэ мэдлэг, технологид үндэслэн 2018 онд байгуулагдаж байгаа бөгөөд зах зээлд дараах бүтээгдэхүүн, үйлчилгээг санал болгож байна.

- VR-д суурилсан бүрэн симулятор
Хүнд машин механизм, төхөөрөмжийн сургалтанд зориулсан
- 3 хэмжээст загварчлал ба хэвлэл
Өгөгдсөн биетийн 3 хэмжээст загварыг лазерь болон фото сканнерын тусламжтай өндөр нарийвчлалтай байгуулах, хэвлэх
- VR болон AR-д суурилсан маркетинг
Орчин үеийн дэвшилтэт технологид суурилсан бүтээгдэхүүний сурталчилгаа
- Газар зүйн 3 хэмжээст загварчлал
Дронд суурилуулсан технологийг загварыг өндөр нарийвчлалтай байгуулах



✉ enkhbayar.a@seas.num.edu.mn

☎ 94000133

🌐 <http://cglab.seas.num.edu.mn>

- 3 хэмжээст
- Виртуал реалити (VR)
- Проект
- 3 хэмжээст
- Математик
- Компьютер
- Авгментэд реалити (AR)
- Дронд суурилсан



Өндөр гэгээн ЗАНАБАЗАРЫН бүтээлүүдийн дижитал загварыг байгуулах



Цагаан дара эх (68x45x45cm) Ногоон дара эх (68x45x49cm) Маш гийүүлэн зохиогч (71.5x45.5x45.5cm)



“ЭНХ-ТУНХ”

БАГИЙН ГИШҮҮД:

О.Оргил-Эрдэм ХШУИС, Материал судлал, шинэ материалын технологи, 3-р түвшин
Д.Ану-дарь БС, Санхүү банк, 3-р түвшин

Б.Нямцэрэн ХШУИС, Материал судлал, шинэ материалын технологи, Магистрант

Б.Лхам-Эрдэнэ ХШУИС, Нано инженерчлэл, 4-р түвшин

Б.Энхзаяа ХШУИС, Материал судлал, шинэ материалын технологи, Магистрант

Б.Гэрэлчимэг ХШУИС, Химийн инженер, Магистрант,

УВДИСТ эмчилгээний зохиомол шаврыг байгалийн эрдэс түүхий эдээс зохиомол аргаар бэлтгэн гаргасан бөгөөд тус бүтээгдэхүүн нь хүний биед зайлшгүй шаардлагатай макро, микро элементийн агуулга ихтэй, бальнеологийн болон физик-химийн шинж чанар, эрдэс химийн найрлагаараа эмчилгээний шаврын шаардлагыг хангасан бүтээгдэхүүн юм.

Уг шаврын радикулит, хуян, төрөл бүрийн гаралтай үе мөчний өвчний үед биеийн өвчтэй хэсэгт 15-20 минутын турш тавьж хэрэглэнэ. Хадгалах хугацаа 0°C температурт, 3-4 сар.

УВДИСТ эмчилгээний зохиомол шавран маск нь байгалийн эрдэс түүхий эдээс зохиомол аргаар бэлтгэн гаргасан бөгөөд тус бүтээгдэхүүн нь хүний биед зайлшгүй шаардлагатай макро, микро элементийн агуулга ихтэй, бальнеологийн болон физик-химийн шинж чанар, эрдэс, химийн найрлагаараа эмчилгээний шаврын шаардлагыг хангасан бүтээгдэхүүн юм.

Уг маскийг нэрсэн усаар зуурч биеийн өвчтэй хэсэгт шууд тавьж хэрэглэхээс гадна, гоо сайхны зориулалтаар маск болгон хэрэглэхэд нэн тохиромжтой бүтээгдэхүүн болно. Хадгалах хугацаа тасалгааны температурт 3 жил.

БҮТЭЭГДЭХҮҮНИЙ НЭР:

УВДИСТ эмчилгээний зохиомол шавар

ТӨСЛИЙН УДИРДАГЧ:


Б.Цэрэнханд

ХШУИС, ХБИТ, Дэд профессор



✉ tserenkhand@seas.num.edu.mn

☎ 7730-7730 (3201)



Найрлага:
Уг эмчилгээний шавар нь найрлагандаа хүний бик организмд чухал нөлөө бүхий макро болон микро элементүүд, тухайлбал цайр, кальци, магни, зэс бүхий байгалийн эрдэст шавар болон молекул орны гүний цэнгээг рашааныг агуулсан органик бүтээгдэхүүн юм.

Хэрэглэх заавар:
Харшил гарсан болон үрэвсэлтэй арьсан дээр шууд түрхэж 15-20 минутын дараа халуун бүлээн усаар угааж хэрэглэнэ.

Монголд үйлдвэрлэв





"MONGOLIAN BIO FUTURE" MBFU

БАГИЙН ГИШҮҮД:

Г.Намуунаа МУИС, ХШУИС, Биоинженерчлэл (4-р түвшин)

П.Мандарваа МУИС, БС, Менежмент (4-р түвшин)

Ц.Золзаяа МУИС, ХШУИС, Биоинженерчлэл (Магистрант)

Х.Сувд-Эрдэнэ МУИС, ШУС, Хими (3-р түвшин)

М.Баярмаа МУИС, ХШУИС, Биоинженерчлэл (4-р түвшин)

Г.Хастулга МУИС, ШУС, 1-р түвшин

"Цомцогт бэр цэцэг (*Scabiosa comosa* Fisch.) ургамлаар бэлтгэсэн бактерийн антибиотикт тэсвэрлэх чадварыг бууруулах идэвхтэй ам зайлагч" нь цэвэр байгалийн гаралтай бүтээгдэхүүн бөгөөд тус бүтээгдэхүүний үндсэн найрлага болох Цомцогт бэр цэцгийн өтгөрүүлсэн ханд нь антибиотикт тэсвэртэй болсон микроорганизмын эсрэг өндөр идэвхитэй юм. Зах зээлд зарагдаж буй бусад ам зайлагч бүтээгдэхүүнүүд нь ихэвчлэн химийн гаралтай мөн будагч бодис их агуулдагаас гадна зөвхөн бактерийн эсрэг идэвх үзүүлдэг байна.

Шинжлэх ухааны хурдацтай хөгжлийн үр дүнд шинэ эмчилгээний аргууд, эмийн бүтээгдэхүүнүүд дэлхийн зах зээлд нийлүүлэгдэж, хүн төрөлхтний эмийн хэрэглээ цар хүрээгээ тэлсээр байгаа боловч үүнтэй зэрэгцэн бидний хүрээлэн буй орчинд амьдарч өвчин үүсгэдэг олон төрлийн нянгууд эмийн нөлөөнд, тэр байтугай ариутгалын бодист хүртэл тэсвэртэй болж хувьсан өөрчлөгдөж байгаа нь анхаарал татсан асуудлуудын нэг болоод байна. Иймээс бактерийн гадны нөлөөнд тэсвэрлэх чадварыг бууруулах идэвхитэй, хүний биед сөрөг нөлөөгүй, байгаль орчинд ээлтэй нэгдлийг ургамлаас олж илрүүлэх, түүнийг хэрэглээнд нэвтрүүлэх судалгаа зайлшгүй шаардлагатай байгаа билээ. Бичил биетнүүд нь гадны сөрөг хүчин зүйлээс өөрийгөө хамгаалах, дасан зохицохын тулд биофилм гэж нэрлэгддэг полисахаридан бүрхүүл үүсгэх, антибиотик нийлэгжүүлэх, эзэн эсийн лейкоцитийг үхүүлдэг рамнолипид ялгаруулах, пигмент үүсгэх зэрэг хариу урвал үзүүлдэг. Бичил биетний эдгээр процесс нь ауто-өдөөгч (auto-inducer)-ийн экспрессээр идэвхиждэг Quorum sensing (QS) механизмаар зохицуулагддаг.

Бидний хийж буй бүтээгдэхүүний гол давуу тал нь амны хөндийд байршин шүд болон буйлыг үрэвсүүлэн өвчин үүсгэж буй бактерийн бөөгнөрөлийн гадна талаар үүссэн биофилмийн бүрхүүлийг устгах (антибиотикт тэсвэртэй болсон чадварыг устгах) буюу уг бүрхүүл үүсэхээс урьдчилан сэргийлэх ач холбогдолтой бөгөөд нөгөө талаас амны хөндийн ашигтай микрофлорыг устгахгүйгээрээ онцлог юм.

ТӨСЛИЙН НЭР: “Цомцогт бэр цэцэг
(*Scabiosa comosa* Fisch.) ургамлаар бэлтгэсэн
бактерийн антибиотикт тэсвэрлэх чадварыг
бууруулах идэвхтэй ам зайлагч”

БҮТЭЭГДЭХҮҮНИЙ НЭР: Uniqare

ТӨСЛИЙН УДИРДАГЧ:

Б. Даваапүрэв

ХШУИС Ахлах багш, доктор

UNI^QARE 
Mouthwash

✉ davaapurev@seas.num.edu.mn

☎ 7730-7730 (3212)





"WARM DATA"

БАГИЙН ГИШҮҮД:

Б.Бадамхатан ХШУИС, СЭХ инженер
Э.Зандаргираа ХШУИС СЭХ инженер- Магистрант
Г.Мэргэн БС, Менежмент, 2-р түвшин
Э.Отгонзул ХШУИС, СЭХ инженер- судалгааны ажилтан
Ц.Сэргэлэн ХШУИС, СЭХ инженер, 4-р түвшин
Г.Тамир ХШУИС, СЭХ инженер, Магистрант
Ц.Чулуунтогтох ХШУИС, СЭХ инженер, 4-р түвшин
Ө.Элбэрэл ХШУИС, СЭХ инженер, 5-р түвшин
О.Мөнхнасан БС, Санхүү менежмент, 2-р түвшин

Улаанбаатар хотын агаарын бохирдлын дийлэнх хэсгийг үүсгэж буй гэр хорооллын айл өрхүүд гэр, байшингаар нь дулаан алдагдал хэрхэн явагддаг, байшингаа зөв зохистой төлөвлөн барих болон дулаалах нь эдийн засгийн болоод эрчим хүчний хэмнэлт авчирдаг талаар ойлгоц муу байгаа нь энэ талаарх үнэн зөв мэдээ, мэдээлэл байнгын түгээж байх систем дутагдалтай буйгаас үүдэлтэй юм. Иймээс бид дулаан алдалт, дулаалгын талаархи мэдээ мэдээллийн нэгдсэн санг хөгжүүлж байна.

Мөн манай веб аппликейшн нь утааг бууруулах зорилготой төслүүд хэрэгжсэн айлуудын мэдээллийг олон нийтэд нээлттэй үзүүлэх боломжийг бүрдүүлэх ба ингэснээр олон нийтийн хяналтыг сайжруулах, эрчим хүчний болон нүүрсхүчлийн хийн хэмнэлтийн бодит жишээнүүдээр дулаалгын ач холбогдлыг нийгэмд ойлгуулах ажлыг гүйцэтгэх юм. Олон нийтийн санхүүжилт төвлөрүүлэх систем үүсгэн санхүүгийн боломжгүйн улмаас дулаалгын төсөлд хамрагдаж чадахгүй байгаа айлуудын дулаалгын зардлыг бүрдүүлэх системийг хөгжүүлэхээр зорин ажиллана.

Манай веб аппликейшн нь :

- » Дулаалгын зөв зохистой арга технологи, бодит жишээнүүд
- » Дулаан алдагдал болон ачааллыг тооцох хялбарчилсан тооцоолуур
- » Дулаалгатай холбоотой үйл ажиллагаа эрхлэгч байгууллагуудын холбогдох мэдээлэл
- » Төслүүдийн бодит жишээнүүдийн нэгдсэн мэдээллийн сан
- » Эрчим хүчний болон нүүрсхүчлийн хийн хэмнэлтийг бодит цагын утгыг харуулах газрын зураг
- » Олон нийтийн санхүүжилтийн платформ зэргийг агуулсан байна.

ТӨСЛИЙН НЭР: WARM data

ТӨСЛИЙН УДИРДАГЧ:

А.Амарбаяр


ХШУИС Дэд профессор



 amarbayar@seas.num.edu.mn

 99045070

 www.itel.club
www.hackutaa.ml



Дулааны ачааллын тооцоолол хийх сар-аа сонгоно уу?

Нэгдүгээр сар

Баруун зугруу харсан ханын үзүүлэлтүүдийг энд оруулна уу.



Ханын өргөн, м	Ханын өндөр, м
5	2.7
Ханын 1-р үе	1-р үеийн зузаан, м
Хөнгөн бетон (800кг/м3)	0.36
Ханын 2-р үе	2-р үеийн зузаан, м
Полистирол хавтан (30кг/м3)	0.12
Ханын 3-р үе	3-р үеийн зузаан, м





ЭРДЭМТ ХҮНС

“ЭРДЭМТ ХҮНС”

БАГИЙН ГИШҮҮД:

Ш.Ариунзаяа ШУС-БУС, Хими, 3-р түвшин

Ү.Батмагнай БС, 2-р түвшин

Б.Хонгорзул БС, 2-р түвшин

Б.Гандирмаа БС, Санхүү эдийн засаг, 3-р түвшин

С.Анударь БС, Санхүү, эдийн засаг, 3-р түвшин

Т.Анударь БС, Банк санхүү, 3-р түвшин

Г.Хишигдулам БС, Нябо, 3-р түвшин

Д.Батмэнд ШУС-БУС, Хими, 3-р түвшин

Л.Дэлгэрмөрөн ШУС, НУС, 3-р түвшин

Манай орны хувьд шар сүү нь сүүн бүтээгдэхүүн үйлдвэрлэх явцад хаягдал байдлаар гардаг. Үүнийг хаяснаар задрах явцдаа хөрсөнд байх хүчилтөрөгчийг маш ихээр шингээдэг тул хүрээлэн буй орчинд хортойгоор нөлөөлдөг билээ. Сүүний үйлдвэрүүд шар сүүг зохистой ашиглахгүй, хаях нь элбэг байна. Энэ нь малын гаралтай нөөцийг үр бүтээлтэй ашиглахгүй байгаагийн илрэл бөгөөд шар сүүг хаялгүйгээр иж бүрэн боловсруулах нь сүүлийн жилүүдэд дэлхий дахинд маш хурцаар яригдах болсон экологийн хувьд аюулгүй үйлдвэрлэлийг хөгжүүлэх шаардлага хэрэгцээг хангах юм.

Шар сүү боловсруулахдаа шар сүүний гэдэс гүйлгэдэг шинж чанарын шалтгаан лактозыг экологийн катализатор ашиглан элэг хамгаалах, дархлаа дэмжих үйлчлэлтэй лактулозд хувирган шар сүүний эмчилгээний чанарыг улам нэмэгдүүлж байгаараа шинэлэг бүтээгдэхүүн болох юм.

Энэхүү бүтээгдэхүүнийг үйлдвэрлэх процесс нь шат дамжлага багатай, сүүний үйлдвэрийн хаягдлыг боловсруулж эрүүл мэндийг дэмжих бүтээгдэхүүн үйлдвэрлэхээрээ дэвшилттэй.

Онцлог, ач холбогдол:

- Биеийн алжаал, ядаргаа тайлж, дархлаа дэмжих,
- Элэг хамгаалах
- Уургийн хэрэгцээг хангах
- Бодибилдингийн спортоор хичээллэгч бүлчингийн масс нэмэх,
- Хүний биед зохимжтой, удаан хугацаагаар хэрэглэхэд сөрөг нөлөөгүй
- Ходоод гэдсэнд пребиотикийн үүрэг гүйцэтгэнэ.

ТӨСЛИЙН НЭР: “Жангар” энергийн ундаа

ТӨСЛИЙН УДИРДАГЧ:

Б.Мөнхжаргал ШУС, БУС Дэд профессор

Б.Туяагэрэл ШУС, БУС Багш Доктор



ЭРДЭМТ ХҮНС

✉ monkhjargal@num.edu.mn
tuyagerel@num.edu.mn

☎ 7730-7730 (2486)





Active new

"ACTIVE NOW"

БАГИЙН ГИШҮҮД:

Э.Отгон-Эрдэнэ БС, Санхүү менежмент, 3-р түвшин

Г.Нарантулга БС, Нябо, 3-р түвшин

А.Мягмарнаран БС, Нябо, 3-р түвшин

Ж.Цэрэнчимэг БС, Санхүү менежмент, 4-р түвшин

Д.Нарантуяа БС, Санхүү менежмент, 3-р түвшин

З.Мөнгөнтуяа БС, Санхүү менежмент, 3-р түвшин

Монголын эрс тэс уур амьсгалын улмаас хүмүүс "Өглөө даарах уу? Өдөр халууцах уу?" гэсэн сонголт гарч ирдэг. Өмсөж явсан хүрмээ өдөр нь зөөвөрлөж явахад төвөгтэй, явж байсан газраа орхих, наранд их удаан байлгаснаар өнгө алдах, бүсэлхийгээрээ уясанаар үрчийх зэрэг дутагдалтай байдаг.

Эдгээр асуудлуудыг шийдэхийн тулд цамц, бомбер, бэлтгэлийн хослол, үндэсний хэв маягаа шингээсэн цамц, нимгэн хүрэм гэх мэт бүтээгдэхүүнээс бүрдсэн IDeax брэндийг бий болгохыг зорьсон юм. IDeax брэндийн бүтээгдэхүүн маань хэрэгцээт хүн бүхэнд зориулагдсан.

Хүйтэнд хөрөхгүй, халуунд халахгүй зөөвөрлөхөд хялбар, өөрт хэрэгцээтэй аливаа зүйлсийг цүнхэндээ давхар хийх зэрэг олон давуу талыг бий болгоно. Энэхүү төсөл хэрэгжсэнээр энгийн гадуур хувцастай ижил үнэтэй хэдий ч нэгийн үнээр хоёр бүтээгдэхүүн авах боломжийг олгох ба олон төрлийн давуу талыг өөртөө шингээсэн учраас хэрэглэгчдэд очих үнэ цэнэ, сэтгэл ханамж нь маш өндөр болох юм.

Манай бүтээгдэхүүнүүд малгайтай, малгайгүй, сүл загвартай, задгай энгэртэй гэх мэт өнгө загвар, размерийн өргөн сонголттойгоор уламжлалт болон орчин үеийн хэв маягийг шингээн урлагдах болно.

ТӨСЛИЙН НЭР: IDEAX

ТӨСЛИЙН УДИРДАГЧ:

Д.Батцэцэг

БС-ийн багш, Магистр

ACTIVE NOW

✉ dalhbattsetseg@yahoo.com

☎ 94045616





"NUM SKILL"

БАГИЙН ГИШҮҮД:

М.Зоригт ОУХНУС, ОУХ, 4-р түвшин

Б.Оюунжаргал ОУХНУС, ОУХ, 3-р түвшин

Ж.Мөнхдэлгэр ХШУИС, Статистик, 4-р түвшин

Б.Бандихүү ХШУИС, Мэдээллийн технологи, 4-р түвшин

Ж.Хайнзан БС, Ня-бо, 1-р түвшин

Б.Баянмөнх ОУХНУС, ОУХ, 4-р түвшин

О.Азгэрэл БС, Менежмент, 3-р түвшин

Бид МУИС-ийн багш, оюутан учраас сургуульдаа хэрэгтэй зүйл хийе гэж анх санаагаа хайж эхэлсэн. Маш олон санаа гарч, янз бүрээр хувирч өөрчлөгдсөөр байгаад эцэст нь оюутнуудаас санал асуулга явуулж тэдний хэрэгцээг судласан. Оюутнууд хичээлийн бус цагаар ур чадвар, хандлагаа хөгжүүлэх сонирхолтой байдаг ч нөхцөл боломж бага, сургалтын төлбөр, өдөр тутмын хэрэгцээг хангах мөнгө олохын тулд цагаар ажиллах сонирхол ихтэй байдаг зэрэг нь бидний анхаарлыг татсан.

Энэ бүхнийг харгалзан МУИС-ийн байгаль, нийгмийн ухааны чиглэлээр суралцаж буй бүх оюутнуудад ур чадвар, хандлагаа хөгжүүлэх, харилцан суралцах, мэдлэг, чадвараа сорих орчин бүрдүүлэх зорилгоор бизнесийн санаагаа хөгжүүлж байна.

Мөн бид оюутан та бүхэнд хичээлийн бус цагаараа суралцах уян хатан цагийн хуваарьтай ур чадвар олгох сургалтуудыг санал болгох бөгөөд ур чадвар шаардагдсан цагийн ажилд зуучлах веб сайт, аппликэйшн хөгжүүлж түүгээрээ дамжуулан мэд-ээллээ тасралтгүй түгээж байх болно.

Та биднийг дэмжээрэй, бид та бүхэнд туслана!

ТӨСЛИЙН НЭР: NUM SKILL

ТӨСЛИЙН УДИРДАГЧ:


С.Энхцэцэг

ОУХНУС, Дэд профессор



✉ enkhtsetseg@num.edu.mn

☎ 7730-7730 (5105)





“ECO PUZZLE”

БАГИЙН ГИШҮҮД:

М.Долгормаа ХШУИС, Хими биологийн
инженерчлэлийн тэнхмийн лаборант, магистр
Б.Энх-Учрал ХШУИС, ХБИТ магистр
О.Оюун-Эрдэнэ ХШУИС, ХБИТ магистрант
Г.Золбоо ХШУИС, ХБИТ магистрант

Манай улс сард 110000 кг цаасан бүтээгдэхүүнийг импортоор оруулан хэрэглэдэг бөгөөд БНХАУ руу хаягдал цаасаа 1 тонныг нь 5000-50000 төгрөгөөр худалдаж буцаагаад нэг тонныг нь 2.3 сая төгрөгөөр худалдаж авдаг байна.

Бид цаас үйлдвэрлэгч орон биш хэдий ч Улаанбаатар хотын албан тасалгаа болон ахуйн хэрэглээнээс үүсч буй нийт хог хаягдлын 70%-ийг цаас эзэлдэг. Улаанбаатар хотын том хогийн цэгүүд болох Нарангийн Энгэр, Морингийн даваа болон Цагаан давааны хогийн цэгүүдэд цаасны хаягдал нь ямар нэг ангилан ялгалтгүйгээр шууд ачигдан ирж булагддаг.

Байгаль орчны яамнаас гаргасан тайлангийн дагуу эдгээр үүссэн хаягдал цаасны ердөө 3% нь л манай оронд дахин боловсруулагддаг бөгөөд үлдсэн хувь нь шууд ландфиллд хаягдсаар байна.

Энэ нөхцөл байдалд тулгуурлан бидний гол анхаарлаа хандуулах зүйл бол хоёрдогч бохирдуулагч буюу импортоор авч хэрэглэсэн цаасыг хэрхэн зүй зохистой хаях, хэрхэн боловсруулж дахин хэрэглээнд нэвтрүүлэх бүтээгдэхүүний шийдэл юм.

Манай бүтээгдэхүүн нь ерөнхий боловсролын сурагчдаас эхлэн бүх насныханд зориулагдах, дахин боловсруулсан цаасаар хийсэн экологид ээлтэй, танин мэдэхүйн болон бүтээлч сэтгэлгээг хөгжүүлэхэд чиглэгдсэн “STEM-Puzzle” юм. Уг төслийн зорилго нь дахин боловсруулсан цаасны хэрэглээг нэмэгдүүлэх, дотоодод үйлдвэрлэсэн танин мэдэхүйн бүтээгдэхүүнийг гаргах болон нийгэмд хог хаягдлыг зөвөөр хаях, ялгах зэрэг зөв хандлагыг бий болгох зэрэг болно.

ТӨСЛИЙН НЭР:

Дахин боловсруулсан цаасан бүтээгдэхүүний үйлдвэрлэл

БҮТЭЭГДЭХҮҮНИЙ НЭР:

“STEM-Puzzle”

ТӨСЛИЙН УДИРДАГЧ:


Т.Энхдөл

ХШУИС, Дэд профессор



✉ dolgormaa@num.edu.mn

☎ 7730-7730 (3411)





“МОН БИО ПРО”

БАГИЙН ГИШҮҮД:

Ц.Уранчимэг ШУС-БУС, Хими, 4-р түвшин

Л.Дулмаа ШУС-БУС, Хими, 4-р түвшин

Л.Халиун ШУС-БУС, Хими, 4-р түвшин

Б.Батзаяа ШУС-БУС, Хими, 4-р түвшин

Г.Батсугар ШУС-БУС, Биологи, 4-р түвшин

О.Халиундарь ШУС-БУС, Эдийн засаг, 3-р түвшин

Компаний зорилго нь Монгол орны түүхий эдийг ашиглан үндэсний бренд бүтээгдэхүүн шинээр бий болгох явдал юм.

Энэ зорилгоор монгол оронд ургадаг агил мөөг болон каолин шавраас АГАРИЦИНТАЙ ШАВАР БИГНҮҮР бүтээгдэхүүнийг бэлтгэн гаргана.

Агарицинтай шавар бигнүүр нь нүүрний арьсыг цайруулах, арьсны нүх агшаах, нүүрний арьсны тослогийг тэнцвэржүүлэх, хорыг тайлах, үрчлээ багасгах, батга үрэвслийг эмчлэх зэрэг үйлчлэлтэй.

Агарицинтай шавар бигнүүрийн найрлаган дахь каолин шавар нь нүүрний илүүдэл тос болон бохирдлыг шингээдэг ба эрдэс элементийг ихээр агуулах тул арьсанд тэжээл өгч нүүрний арьсны булчинг амраах, арьсны нүх сүвийг багасгах зэрэг олон талын үйлчлэл үзүүлдэг. Ийм учраас энэ нь олон төрлийн маскны суурь болгон хэрэглэгддэг. Агарицин нь тосны хүчлийн нийлэгжилийг ихээр дарангуйлдаг (U.S.patent application Ser .No.11/029,861), хөлсний булчирхайг мэдээгүйжүүлж, хөлс ялгарлыг багасгадаг үйлчилгээтэй.

ТӨСЛИЙН НЭР:

Агарицитай шавар бигнүүр үйлдвэрлэх

ТӨСЛИЙН УДИРДАГЧ:

Ш.Наранмандах

ШУС, БУС Профессор



Агарицны хучил, каолин шавартай эмчилгээний маск

Энгийн маск нь тосмолтой танинжруулж, тусгай нэмэлт,
хоч ашиглах, цайруулах үйлчилгээтэй бодогддог юм.

Хэрэглэх аргаар: Нм хавчга мэхин бүтэцтэй усар найруулж
дотуулай арьсанд жигд түгээх. Хавчга дорхи бүтэцтэй усар
утгай, дотооноос 2-3 удаа хэрэглэх.

✉ smandakh@num.edu.mn

☎ 7730-7730 (2438)

